

**ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2018/99/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Хонгорзул
Утас: 260512 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Аудитор Б.Ариунжаргал
Утас: 260512 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт	3
2.6	Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар.....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар	4
2.9	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	5
2.10	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.10.1	Мөнгөн хөрөнгийн талаар	5
2.10.2	Авлага, өглөгийн талаар	6
2.10.3	Бараа материалын талаар:.....	6
2.10.4	Орлогын талаар:.....	7
2.10.5	Зардлын талаар	7
2.10.6	Нягтлан бодох бүртгэлийн талаар:.....	8
2.10.7	Дотоод хяналтын талаар:.....	8
2.10.8	Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаар:.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	9
2.15	Аудитын үр өгөөж.....	9
2.16	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал	10
3.1.	Мөнгөн хөрөнгийн талаар.....	11
3.2.	Авлагын талаар.....	12
3.3.	Бараа материалын талаар.....	13
3.4.	Зардлын талаар.....	14
3.5.	Зорилтот түвшний талаар	15
3.6.	Дотоод хяналтын талаар.....	16
3.7.	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	17
3.8.	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	18
3.9.	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
3.10.	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус байгууллагын ерөнхий захирал Ё.Нямжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, бэлэн мөнгөний үлдэгдэл, хүнсний материалын үлдэгдэлд сар бүр тооллого хийж, үр дүнг тооцож ажиллах, авлага, өглөгийг бууруулах, тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн хөрөнгө бэлтгэхдээ холбогдох газраас зөвшөөрөл авч байх, төсвийг үр ашигтай зарцуулах, байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг журмын дагуу ажиллуулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “ Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа НББОУС, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” болон бусад холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 6-наас 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 13-нд эцэслэн баталгаажуулж, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын



удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул, аудитор Б.Ариунжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн ДБ 05/85 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дипломат харилцааны тухай Венийн 1961 оны конвент, олон улсын түгээмэл жишгийн дагуу тухайн улсад суугаа бусад улсын Дипломат болон Консулын төлөөлөгчийн газрууд, Олон Улсын байгууллагын хэрэгцээний газар, албаны байр олж авах, газар, байрны эзэмшил, ашиглалттай холбоотой бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллах Гадаад харилцааны яамны чиг үүргийг түүний харъяа “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь дээрх зохицуулалт, жишгийн дагуу Гадаад явдлын яамны бүтцэд анх 1951 онд “Элчингүүдэд үйлчлэх тасаг” нэртэй 1 орон тоотой байгуулагдснаас хойш өдгөө 67 жилийн түүхэн замналтай, 130 гаруй албан хаагчидтай ТӨААТҮГ болон өргөжин тэлж үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол Улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор ханган ажиллах үндсэн зорилго, зорилтын хүрээнд дараах нийтлэг үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын барилга байгууламж, цахилгаан, сантехникийн засвар үйлчилгээ, тохижилт;
- Монгол Улсад зохион байгуулагдаж буй Төрийн бүх түвшний айлчлал, хүндэт зочид төлөөлөгчид, Гадаад харилцааны яам, Монгол улсад суугаа Элчин сайдын яамд, Консулын газрууд, Олон Улсын байгууллагын төлөөлөгчийн газрын захиалгын дагуу автомашины үйлчилгээ;
- Дипломат төлөөлөгчийн газрууд нь Төрийн тусгай хамгаалалттай объектуудад байршдаг ба Олон Улсын эрх зүйн актад тусгагдсан чиг үүргийн хүрээнд объектын бүрэн бүтэн байдал, тэдний ажиллах орчин нөхцөлийн аюулгүй ажиллагааг хуулийн хүрээнд сахин хамгаалах;
- Төрийн хэмжээний айлчлал болон Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчийн газруудын хүсэлтээр ёслол хүндэтгэлийн хүлээн авалт, арга хэмжээг зохион байгуулж, чанар, стандартын өндөр түвшинд хүрсэн зоогийн үйлчилгээгээр үйлчлэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхдээ “Олон улсын стандартын түвшинд хүрсэн найдвартай, мэргэшсэн үйлчилгээ бүхий өрсөлдөх чадвартай байгууллага болох” гэж байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газартай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр

тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, дүрэм, захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаар батлах тухай” 83 дугаар тогтоолоор орон тооны хязгаарыг 138 байхаар тогтоосноос 2017 оны жилийн эцсийн байдлаар Захиргааны хэлтэс-15, Санхүү эдийн засгийн хэлтэс-9, Үйлчилгээ, ашиглалтын хэлтэс-110, нийт 134 хүн үндсэн ажилтнаар, гэрээт 10 хүн ажиллаж байна.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан. ТАБ-СТА-А-1

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ -ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 17 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.10 дах заалтад хураангуйлан тэмдэглэв.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ -ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа ГҮҮК СОФТ ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн “Axplorer 3.16” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын ажилтан нь 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө хөтөлбөр боловсруулан батлуулж ажилласан боловч

гүйцэтгэсэн ажлын талаар тайлан гаргаагүй, бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлээгүй, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүй, өгсөн зөвлөмж байхгүй зэргээс санхүүгийн үйл ажиллагаанд тавьсан хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд илэрч байна.

2.6 Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

ТӨБЗГ-аас “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын захиралтай байгуулсан 2017/28 дугаар контрактаар тус байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны зорилтот түвшингээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн нийт орлогыг 4,897.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,853.2 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө оруулалтын зардалд нийт 24 төрлийн бараа, ажил үйлчилгээнд 301.8 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Тайлант онд гүйцэтгэлээр нийт 5,244.3 сая төгрөгийн үйл ажиллагааны, 167.3 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлого бүрдүүлж, урсгал зардалд 5,320.4 сая төгрөг зарцуулж, 14,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз, 37,2 сая төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүгийн гарзыг хүлээн зөвшөөрч, 35.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь тайлант онд 2016 оны төрийн өмчийн ногдол ашигт 6.2 сая, төрийн өмчийн түрээсийн орлогын 30 хувь 382.9 сая, нийт 389.1 сая төгрөгийг ТӨБЗГ-т шилжүүлсэн байна.


2.7 Шилэн дансны мэдээлэл

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь байгууллагын цахим хуудас mof.gov.mn сайтад шилэн дансны цэсийг холбож “Шилэн дансны тухай” хуульд заасны мэдээллийг тухай бүр бүрэн оруулж хэвшсэн байна. Тухайлбал: Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан тухай холбогдох баримт, тушаал, шийдвэр, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ зэрэг мэдээллийг бүрэн оруулсан байна.

2.8 Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь 2016 оны 5-6 дугаар сард Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулах үйл ажиллагаанд зориулж БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн нийт 578 иж бүрдэл зочид буудлын тавилга, 13773ш цагаан хэрэглэл (дэр, дэрний уут, гарын алчуур, матрасны углаа, ор, хөнжлийн даавуу, ванны алчуур, толгойн алчуур гэх мэт), 5456ш албан тасалгааны тавилга, эд хогшилыг хүлээн авсан байна.

ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, АСЕМ-ын ажлын албаны даргын 2016 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн А/180 дугаар тушаалаар БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ГХЯ-ны нэр дээр ирсэн болон төсвийн хөрөнгөөр худалдан авч хэрэглэсэн хурлын тавилга, техник, тоног төхөөрөмжийг бүртгэн хураан авч цаашид яамны үйл ажиллагаанд ашиглаж болох эд зүйлс, ашиглагдахгүй илүүдэл хэсгийг тодорхойлон гаргах, зарж борлуулан улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-т хариуцуулсан байна.



Дээрх шийдвэрийн дагуу “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь 2016 онд зочид буудлын 475 иж бүрдэл тавилгуудыг АСЕМ-ын түнш зочид буудлууд болон хувь хүн, ААН-д 1.171.4 сая төгрөгөөр, 670 ш албан тасалгааны тавилга эд хогшлыг 102.2 сая төгрөгөөр байгууллага хувь хүмүүст худалдсан, зочид буудлын 103 иж бүрдэл тавилгуудыг 233.8 сая төгрөгөөр, албаны зориулалттай нийт 4784ш тавилга, тоног төхөөрөмжийг нийт 34 төсвийн болон ТӨҮГ-уудад 596.9 сая төгрөгөөр үнэлэн үнэ төлбөргүй шилжүүлжээ.

ТӨБЗГ нь дээрх хөрөнгийн үнэлгээг 2017 онд /ДБУЭГ-ын тогтоосон үнээр/ 14 төрийн байгууллагад нийт 599.2 сая төгрөгийн 4784 ш нийт албан тасалгааны тавилга тоног төхөөрөмж, 233.9 сая төгрөгийн 103 иж бүрдэл зочид буудлын тавилгыг үнэ төлбөргүй шилжүүлж, данс бүртгэлд бүртгэх зөвшөөрөл, 475 иж бүрдэл зочид буудлын тавилгыг 1,171.4 сая төгрөгөөр, 670 ш бусад тавилга, тоног төхөөрөмжийг 102.2 сая төгрөгөөр тус тус үнэлэн байгууллага иргэдэд худалдан борлуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхийг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ -т даалгасан байна.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ нь ТӨБЗГ-ын дээрх тогтоол шийдвэрийн дагуу нийт 1,273.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулснаас 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 763.7 сая төгрөгийн орлогыг хураан авч, орлогоос хөрөнгө хадгалах, тээвэрлэх, хуваарилахтай холбогдон гарсан 116.7 сая төгрөгийг суутган тооцож, нийт 644.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 509,9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант оны сүүлчээр орсон 3.0 сая төгрөгийн орлогыг жилийн эцсийн санхүүгийн тайланд улсын төсөвт төлөх өглөгөөр тайлагнасан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны А/204 дүгээр тушаалаар Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт "АСЕМ"-ыг зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүнд хийгдэж байгаа эрсдлийн аудитын тайланд дээрх хандив тусламжийн хөрөнгөтэй холбоотой зөрчлийн талаар дэлгэрэнгүй тусгагдана.

2.9 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.10-т хураангуйлан тэмдэглэв.

2.10 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.10.1 Мөнгөн хөрөнгийн талаар

- Тайлант онд 208.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг касст бэлнээр тушаалгасан, сар бүрийн бэлэн мөнгөний үлдэгдэл дунджаар 10.6 сая төгрөг буюу зарим сард 15.7-22.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тус байгууллагын НБББББ-ийн 1-ийн 5 дах заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын кассанд хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийж, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ



захирлын тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 1.5 дах заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

- Бэлэн мөнгөний үлдэгдэлд сар бүр тооллого хийж тооцоог бодон, үр дүнг баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т *“Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”*, 70.2.4-т *“мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал ... сар бүрийн 1-нээр”* гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөн байгууллагын кассын үлдэгдлийг сар бүр тоолж, тооцоог бодон үр дүнг тооцож ажиллах талаар зөвлөмж өгөх;

Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар ирсэн хөрөнгийн арилжааны банкинд тушаагдсан борлуулалтын орлогын үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого /2016 оны 5.6 сая, 2017 оны 2.4 сая, нийт 8.0 сая төгрөг/-ыг улсын төсөвт төвлөрүүлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.2-т *“төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого”* нь улсын төсвийн татварын бус орлого гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоох;

2.10.2. Авлага, өглөгийн талаар


Тайлант онд 937.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийн 53.4 хувь нь 4-өөс дээш жилийн насжилттай, 346.9 сая төгрөгийн авлага, 5.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулах, барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өгөх;

2.10.3. Бараа материалын талаар:

- Тайлант онд ТӨБЗГ-тай байгуулсан контрактад тусгагдаагүй 4 хаалгатай хөргөгч, угаалгын машин, богино долгионы зуух зэрэг 3.6 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг худалдан авч, хангамжийн материалын дансанд ангилал буруу бүртгэж тайлагнасан нь УСНББОУС-17 болон Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын 2.2.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т *“... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах”*, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын захирлын ТӨБЗГ-тай байгуулсан контрактын 3.7.2-т *“захирал нь ... үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгө шинээр авахад ТӨБЗГ-ын зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй”* гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Хэмжилт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан;



- Зоогийн газрын хүнсний материалын үлдэгдэлд сар бүр тооллого хийж тооцоог бодон, үр дүнг баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т *"Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана"*, 70.2.4-т *"мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал, болон жижиглэн худалдаалах газар /дэлгүүр, цайны газар, ресторан, бар, зочид буудал гэх мэт/-т ... сар бүрийн 1-нээр"* гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөн цайны газрын үлдэгдлийг сар бүр тоолж, тооцоог бодон үр дүнг тооцож ажиллах талаар зөвлөмж өгөх;

- Тайлант онд худалдаж авсан 7.1 сая төгрөгийн үнэ бүхий шкафыг сэлбэгийн дансанд, 1.7 сая төгрөгийн агаар шүүгч, 0.9 сая төгрөгийн хивс, 0.3 сая төгрөгийн тог баригч, 0.3 сая төгрөгийн цахилгаан дрилийг хангамжийн материалын дансанд ангилал буруу бүртгэн, шууд зарлагдаж тайлант оны үр дүнг нийт 10.3 сая төгрөгөөр бууруулсан нь УСНББОУС-17 болон Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын 2.2.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т *"... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах"*, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨААТҮГ-ын захирлын ТӨБЗГ-тай байгуулсан контрактын 3.7.2-т *"захирал нь ... үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгө шинээр авахад ТӨБЗГ-ын зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй"* гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан;


2.10.4. Орлогын талаар:

ТӨБЗГ-ын 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А-5/2936 тоот албан бичгээр үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 89.7 сая төгрөгийн дансны үнэтэй, Hyundai santa EF маркын 2ш автомашин, ТӨБЗГ-ын 2017 оны 318,319 дүгээр тогтоолуудаар данс бүртгэлдээ бүртгэх зөвшөөрөл олгосон 107.6 сая төгрөгийн хандив, тусламжийн хөрөнгийг орлогод авахдаа үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бус Засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлэн бүртгэж тайлант оны үр дүнг бууруулсан, төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийг түрээслүүлсний орлогын 30 хувь болох 168.8 сая төгрөгийг тайлант хугацааны зардлаар бус урьдчилж төлсөн зардлаар тайлагнаж тайлант хугацааны үйл ажиллагааны зардлыг бууруулж тайлагнасан нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан;

2.10.5. Зардлын талаар

Тус байгууллагаас 2016 онд ажлаас үндэслэлгүй халагдсан Б.Энхцолмон, Г.Ариунболд, М.Номинхүү, Б.Болдбаатар нарт ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгох Шүүхийн шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс ДЗШШ-ээс дахин шийдвэр гарсан, эвлэрсэн зэргээр тус бүр 4-7 сарын цалинг нэмж нөхөн олгоход нийт 18.5 сая төгрөг зарцуулан цалингийн зардлаар тайлагнаж, тайлант оны санхүүгийн үр



дүнг бууруулсан нь “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын захирлын ТӨБЗГ-тай байгуулсан контрактын ТӨААТҮГ-ын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨБЗГ-тай байгуулсан контрактын дагуу байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санаачлагатай ажиллаж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдолгүй зардал гаргахгүй байх зөвлөмж өгөх;

2.10.6. Нягтлан бодох бүртгэлийн талаар:

2017 оны Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн үлдэгдлийг цэвэр дүн, хуримтлагдсан элэгдэл гэж тодруулга тайлангаас 11,363.1 сая төгрөгөөр зөрүүтэй, үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгө худалдсаны 14.4 сая төгрөгийн гарзыг олзоор тайлагнаснаас үйл ажиллагааны бус зардлын дүнг бууруулсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2 “*санхүүгийн тайлан нь үнэн, зөв, баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэсэн, уялдаатай байх*”, 5 дугаар зүйлийн 5.1.4-д “*үнэн зөв байх*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар” - тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

2.10.7. Дотоод хяналтын талаар:

Тус байгууллагын дотоод хяналтын ажилтан нь тайлант онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 2 удаа хяналт шалгалтын ажлын удирдамж батлуулсан боловч гүйцэтгэсэн ажлын талаар тайлан гаргаагүй, бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлээгүй, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүй, өгсөн зөвлөмж байхгүй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.


Шийдвэрлэсэн нь: “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу дотоод хяналтын ажилтны гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлан, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажил үүргээ хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.10.8. Зорилтот түвшний гүйцэтгэлийн талаар:

ТӨБЗГ-ын 2017 оны 380 дугаар тогтоолоор батлагдсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны зорилтот түвшний гүйцэтгэлийг хянаж үзэхэд батлагдсан зардал нийт дүнгээрээ хэтрээгүй боловч байр ашиглалттай холбоотой зардал 57.3 сая, цалин хөлсний зардал 0.5 сая, хангамжийн материалын зардал 4.2 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь ТӨБЗГ-аас “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын захиралтай 2017 онд байгуулсан 2017/28 дугаартай контрактын захирлын хүлээх үүргийн 3.2-т “... *эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр биелүүлэх...*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨБЗГ-тай байгуулсан контрактын дагуу эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр биелүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх;



2.11. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн хэсэгт тусгасан болон залруулаагүй алдаа, АСЕМ-ын хөрөнгийг борлуулсны авлагын барагдуулалтын талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 11,746.0 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 11,727.5 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, нийт 466.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 8.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 374.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 84.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Бодит бүртгэл аудит” ХХК аудит хийж 3 зөвлөмж өгөгдснөөс 2 зөвлөмжийг бүрэн биелүүлж, авлагын үлдэгдлийг барагдуулж ажиллах гэсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,320.3 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувиар буюу 106.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15. Аудитын үр өгөөж

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар нийт 378.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болсныг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн тул үр өгөөжийн бүртгэл /Маягт УАГ 1120/ -д бүртгэсэн болно.

2.16. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1. Мөнгөн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд 208.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг касст бэлнээр тушаалгасан, сар бүрийн бэлэн мөнгөний үлдэгдэл дунджаар 10.6 сая төгрөг буюу зарим сард 15.7-22.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тус байгууллагын захирлын тушаалаар батлагдсан НБББББ-ийн 1-ийн 5 дах заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Мөнгө хөрөнгө дутагдах, санхүүгийн сахилга бат зөрчигдөх;

ҮАГ-ын ажиглалт 2.

Бэлэн мөнгөний үлдэгдэлд сар бүр тооллого хийж тооцоог бодон, үр дүнг баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т *"Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана"*, 70.2.4-т *"мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал ... сар бүрийн 1-нээр"* гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Хууль, эрх зүйн актыг мөрдлөг болгоогүйгээс мөнгө хөрөнгө дутагдах, санхүүгийн сахилга бат зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Байгууллагын касст хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийж, "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨААТҮГ-ын захирлын тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 1-ийн 5 дах заалтыг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсөв захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөн байгууллагын кассын үлдэгдлийг сар бүр тоолж, тооцоог бодон үр дүнг тооцож ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсөв захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2. Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт 1.

Тайлант онд авлага 21.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, нийт авлагын 53.4 хувь нь 4-өөс дээш жилийн насжилттай, 346.9 сая төгрөгийн авлага, 5.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх" гэсэн батламж мэдэглийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах, үлдэгдлийг баталгаажуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өгөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Холбогдох хууль, тогтоомж, журам, заавар зөрчигдөх, найдваргүй авлага бий болох;

Төсөв захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3. Бараа материалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Зоогийн газрын хүнсний материалын үлдэгдэлд сар бүр тооллого хийж тооцоог бодон, үр дүнг баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т *"Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана"*, 70.2.4-т *"мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал, болон жижиглэн худалдаалах газар /дэлгүүр, цайны газар, ресторан, бар, зочид буудал гэх мэт/-т ... сар бүрийн 1-нээр"* гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөн цайны газрын үлдэгдлийг сар бүр тоолж, тооцоог бодон үр дүнг тооцож ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсөв захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4. Зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт 1

Тус байгууллагаас 2016 онд ажлаас үндэслэлгүй халагдсан Б.Энхцолмон, Г.Ариунболд, М.Номинхүү, Б.Болдбаатар нарт ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгох Шүүхийн шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс ДЗШШ-ээс дахин шийдвэр гарсан, эвлэрсэн зэргээр тус бүр 4-7 сарын цалинг нэмж нөхөн олгоход нийт 18.5 сая төгрөг зарцуулан цалингийн зардлаар тайлагнаж, тайлант оны санхүүгийн үр дүнг бууруулсан нь ДБҮЭГ-ын захирлын ТӨБЗГ-тай байгуулсан контрактын ТӨААТҮГ-ын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгө зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулагдах.

ҮАГ-ын зөвлөмж

ТӨБЗГ-тай байгуулсан контрактын дагуу байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санаачлагатай ажиллаж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдолгүй зардал гаргахгүй байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсөв захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.5. Зорилтот түвшний талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

ТӨБЗГ-ын 2017 оны 380 дугаар тогтоолоор батлагдсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын 2017 оны зорилтот түвшний гүйцэтгэлийг хянаж үзэхэд батлагдсан зардал нийт дүнгээрээ хэтрээгүй боловч байр ашиглалттай холбоотой зардал 57.3 сая, цалин хөлсний зардал 0.5 сая, хангамжийн материалын зардал 4.2 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Энэ нь ТӨБЗГ-аас “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨААТҮГ-ын захиралтай 2017 онд байгуулсан 2017/28 дугаартай контрактын захирлын хүлээх үүргийн 3.2-т “... эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр биелүүлэх...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журам зөрчигдөх, төсөв, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

ҮАГ-ын зөвлөмж

ТӨБЗГ-тай байгуулсан контрактын дагуу эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр нь биелүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсөв захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.6. Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагын дотоод хяналтын ажилтан нь тайлант онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 2 удаа хяналт шалгалтын ажлын удирдамж батлуулсан боловч гүйцэтгэсэн ажлын талаар тайлан гаргаагүй, бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлээгүй, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаагүй, өгсөн зөвлөмж байхгүй байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Байгууллагын үзүүлж буй үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамтай нийцэхгүй байх, төсөв, хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, зөрчил давтагдах

ҮАГ-ын зөвлөмж

"Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу дотоод хяналтын ажилтны гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлан, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажил үүргээ хэрэгжүүлж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсөв захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.7. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,316,322,870.20	1,501,285,579.95
1.1.2	Дансны авлага	873,090,199.44	896,153,440.16
1.1.3	Татвар НДШ авлага	42,926,890.56	39,225,022.14
1.1.4	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	2,212,305.00
1.1.6	БАРАА МАТЕРИАЛ	516,456,053.83	518,329,269.04
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,748,796,014.03	2,957,205,616.29
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,941,701,420.09	16,388,163,332.81
1.2.2	Биет бус хөрөнгө	51,858,547.95	51,088,547.96
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,993,559,968.04	16,439,251,880.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,742,355,982.07	19,396,457,497.06
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг /ТӨҮГ/	398,135,413.69	22,562,224.53
2.1.1.2	Цалингийн өглөг	517,206.00	
2.1.1.3	Татварын өглөг /ТӨҮГ/	535,061.78	1,301,887.55
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	399,187,681.47	23,864,112.08
2.2	Өр төлбөрийн нийт дүн	399,187,681.47	23,864,112.08
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	5,843,643,916.35	5,843,643,916.35
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,971,927,181.81	4,971,927,181.81
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,527,597,202.44	8,557,022,286.82
2.3.11	Эздийн өмчийн дүн	19,343,168,300.60	19,372,593,384.98
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,742,355,982.07	19,396,457,497.06



3.8. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,344,458,103.32	5,244,314,844.59
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	5,344,452,678.32	5,244,314,844.59
4	Түрээсийн орлого	4,957,314,633.35	4,679,201,295.64
5	Хүүний орлого	5,861,951.41	79,218,094.91
6	Бусад орлого	381,276,093.56	485,895,454.04
7	Борлуулалт, маркетингийн зардал	3,532,184,947.56	3,429,357,129.35
8	Ерөнхий удирдлагын зардал	803,009,012.37	619,087,649.39
9	Бусад зардал	70,040,891.50	24,800,000.00
10	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	1,090,896,438.09	864,205,244.02
11	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,425.00	382,897,463.10
12	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз)	110,119,238.28	-22,549,762.37
13	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		167,319,068.80
14	Үндсэн хөрөнгө худалдсаны олз (гарз)	8,703,019.92	-14,398,479.21
15	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз)	-81,925,151.79	-14,782,942.62
16	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	31,662,758.95	39,555,279.33
17	Орлогын татварын зардал	789,423.84	3,955,527.93
18	Татварын дараах ашиг (алдагдал)	30,873,335.11	35,599,751.40
19	Зогсоон үйл ажиллагааны татварын дараах ашиг		
20	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
21	Бусад дэлгэрэнгүй орлого		
22	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	5,344,452,678.32	5,244,314,844.59
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.9. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,620,207,674.80	5,644,843,018.49
1.1	Мөнгөн орлогын дүн	5,620,202,249.80	5,644,843,018.49
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,620,202,249.80	5,160,019,033.75
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		100,000.00
	Бусад мөнгөн орлого		484,723,984.74
	Тусламж, санхүүжилтийн орлого	5,425.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,356,092,958.00	5,212,254,509.63
	Ажиллагчдад төлсөн	1,064,310,456.39	1,346,691,480.62
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	246,100,000.00	285,854,133.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	583,612,015.20	460,907,637.17
	Ашиглалтын зардалд төлсөн	1,778,251,577.09	1,716,981,579.41
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	158,064,093.00	170,410,000.92
	Татварын байгууллагад төлсөн	124,497,619.28	147,074,175.68
	Даатгалын байгууллагад төлсөн	47,799,440.00	34,190,006.00
	Бусад мөнгөн зарлага	353,452,332.09	1,050,145,496.83
	Урсгал шилжүүлэг	5,425.00	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,264,109,291.80	432,588,508.86
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2,310,000.00	247,625,799.10
3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,261,799,291.80	184,962,709.76
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,261,799,291.80	184,962,709.76
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,518,153.44	1,316,322,870.19
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,316,322,870.19	1,501,285,579.95



3.10. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,843,643,916.35	4,972,335,686.01		8,496,315,363.13	19,312,294,965.49
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				408,504.20	408,504.20
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				30,873,335.11	30,873,335.11
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт		-408,504.20			-408,504.20
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	5,843,643,916.35	4,971,927,181.81		8,496,723,867.33	19,312,294,965.49
9	2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	5,843,643,916.35	4,971,927,181.81		8,527,597,202.44	19,343,168,300.60
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(6,174,667.02)	(6,174,667.02)
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				35,599,751.40	35,599,751.40
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	5,843,643,916.35	4,971,927,181.81		8,521,422,535.42	19,336,993,633.58
17	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,843,643,916.35	4,971,927,181.81		8,557,022,286.82	19,372,593,384.98



